

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2026/035/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Өмнөговь аймаг 2026 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас:70533539 Цахим хаяг:usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Шижирболд Утас: 70533552 Цахим хаяг: umnugovi@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн : Ай Жэй Эй Эйч аудит ХХК Захирал: Г.Энхмаа Утас: 77450279 99040059 Цахим хаяг:ijahaudit2020@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

---

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>2</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....</b>	<b>4</b>
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>9</b>
<b>Төлбөрийн акт.....</b>	<b>9</b>
<b>Албан шаардлага.....</b>	<b>10</b>
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>11</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.02.25 № 218

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ЭРХЛЭГЧ Б.ТОГОСМАА ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Ханбогд сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Цалин түүнтэй адилтгах орлогоос 78,598.1 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл тооцож тайлагнаагүй, төсөв захирагч өөртөө тушаал гарган 9,189.8 мянган төгрөгийн урамшуулал авсан, илүү цагийн хөлсийг буруу тооцож 32,625.9 мянган төгрөг илүү олгосон, тушаал шийдвэргүй шинжилгээний аялалд 50,800.0 мянган төгрөг зарцуулсан нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нийгмийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 19 дүгээр зүйлийн 19.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 83,101, 117 дугаар зүйл, 16.5.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын Үнэн зөв байх, Тохиолдсон байх, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн хөрөнгө оруулалтаар 1,652,153.1 мянган төгрөгийн 50 ортой эмнэлгийн барилга, Засаг даргын тамгын газраас 257,100.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, унтуулгын аппарат, 12,569.1 мянган төгрөгийн тавилга эд хогшил, бусад хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн байна.

4826758350

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд эрүүл мэндийн даатгалын сангаас 2,868,145.3 мянган төгрөгийн гүйцэтгэлийн санхүүжилт авахаас 808,286.0 мянган төгрөгийн авлагатай гарсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 4 зорилтын хүрээнд 83 арга хэмжээг хэрэгжүүлэн 85.4 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд үнэмлэхүй тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр )

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b><u>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</u></b>	<b>4</b>	<b>548,403,801.82</b>	<b>508,580,612.28</b>
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/		548,403,801.82	508,580,612.28
<b><u>АВЛАГА</u></b>	<b>5</b>	<b>432,769,661.22</b>	<b>432,769,661.22</b>
Татаас, санхүүжилтийн авлага		432,769,661.22	432,769,661.22
<b><u>УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР</u></b>			
<b><u>БАРАА МАТЕРИАЛ</u></b>	<b>6</b>	<b>127,012,497.33</b>	<b>180,169,749.57</b>
<b>Түүхий эд материал</b>		<b>38,473,818.95</b>	<b>99,280,999.57</b>
Тусгай зориулалттай материал		2,937,797.00	2,937,797.00
Эм боох материал		35,536,021.95	96,343,202.57
<b>Хангамжийн материал</b>		<b>88,538,678.38</b>	<b>80,888,750.00</b>
Бичиг хэргийн материал		2,476,175.00	2,441,600.00
Аж ахуйн материал		78,191,411.18	75,076,000.00
Сэлбэг хэрэгсэл		700,000.00	
Түлш, шатах тослох материал		4,082,392.20	
Хүнсний материал		3,088,700.00	3,371,150.00
<b><u>НӨӨЦИЙН БАРАА</u></b>			
<b><u>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</u></b>			
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>1,108,185,960.37</b>	<b>1,121,520,023.07</b>
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>			
<b><u>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</u></b>	<b>7</b>	<b>7,763,321,699.32</b>	<b>9,173,717,059.54</b>
<b><u>Биет хөрөнгө</u></b>		<b>7,463,321,699.32</b>	<b>8,859,002,773.38</b>
Барилга, байгууламж		6,597,967,303.00	8,246,903,657.00
Хуримтлагдсан элэгдэл		(526,651,937.97)	(714,611,841.37)
Авто- тээврийн хэрэгсэл		527,429,434.00	568,829,434.00
Хуримтлагдсан элэгдэл		(192,649,695.18)	(272,207,395.20)
Машин, тоног төхөөрөмж		2,009,148,376.32	2,196,717,602.32
Хуримтлагдсан элэгдэл		(1,124,133,261.48)	(1,330,634,094.94)
Тавилга, аж ахуйн эд хогшил		243,244,509.82	302,868,583.82
Хуримтлагдсан элэгдэл		(149,953,811.04)	(207,690,346.46)
Бусад үндсэн хөрөнгө		107,030,448.00	107,030,448.00
Хуримтлагдсан элэгдэл		(28,109,666.15)	(38,203,273.79)
<b>БИЕТ БУС ХӨРӨНГӨ</b>		<b>-</b>	<b>14,714,286.16</b>
Программ хангамж		400,000.00	17,086,100.00
Хуримтлагдсан элэгдэл		(400,000.00)	(2,371,813.84)
Бусад биет бус хөрөнгө		300,000,000.00	300,000,000.00
Хуримтлагдсан элэгдэл			
<b><u>БУСАД ХӨРӨНГӨ</u></b>	<b>8</b>	<b>300,000,000.00</b>	<b>300,000,000.00</b>
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>7,763,321,699.32</b>	<b>9,173,717,059.54</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>8,871,507,659.69</b>	<b>10,295,237,082.61</b>

<b>Богино хугацаат өр төлбөр</b>			
<b>Өглөг</b>	9	<b>12,240,103.48</b>	-
Ажиллагчидтай холбогдсон өглөг		12,240,103.48	
<b><u>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</u></b>		<b>12,240,103.48</b>	-
Урт хугацаат зээл	10		
<b><u>УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН</u></b>			
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>		<b>12,240,103.48</b>	-
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		<b>8,864,267,556.21</b>	<b>10,670,753,417.63</b>
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		1,051,575,735.75	1,051,575,735.75
Хуримтлагдсан үр дүн		7,098,319,992.09	8,905,827,628.87
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		714,371,828.37	713,350,053.01
Хяналтын бус хувь оролцоо			
<b><u>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН</u></b>		<b>8,864,267,556.21</b>	<b>10,670,753,417.63</b>
<b><u>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</u></b>		<b>8,876,507,659.69</b>	<b>10,670,753,417.63</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр )

ҮЗҮҮЛЭЛТ	Тодруулга	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>			
<b><u>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</u></b>		<b>2,407,365,014.53</b>	<b>3,489,350,295.90</b>
Орон нутгийн төсвөөс		370,230,600.00	621,205,000.00
Нийгмийн даатгалын сангаас		2,037,134,414.53	2,868,145,295.90
<b>Бараа, үйлчилгээний орлого</b>		<b>4,668,206,977.93</b>	<b>3,546,720,179.67</b>
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		466,386,453.00	571,260,310.00
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого		820,073,071.53	1,002,470,020.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		3,316,097,506.59	1,921,822,197.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		65,649,946.81	51,167,652.67
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого			
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	2	<b>7,075,571,992.46</b>	<b>7,036,070,475.57</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>			
<b><u>АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</u></b>		<b>2,407,444,080.88</b>	<b>3,097,813,222.74</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>2,141,651,831.93</b>	<b>2,797,666,976.48</b>
Цалин		957,196,261.15	1,069,859,174.54
Нэмэгдэл зардал		809,116,389.92	1,379,666,424.79
Унаа хоолны хөнгөлөлт		13,091,060.00	10,404,730.63
Урамшуулал		362,248,120.86	337,736,646.52
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>		<b>265,792,248.95</b>	<b>300,146,246.26</b>
Тэтгэврийн даатгалын шимтгэл		195,241,328.46	186,686,223.43
Тэтгэмжийн даатгалын шимтгэл		18,060,676.89	45,304,268.61
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл		9,722,801.14	10,887,572.47
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл		8,953,389.39	10,436,045.45
Эрүүл мэндийн даатгалын хураамж		33,814,053.07	46,832,136.30
<b><u>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ</u></b>		<b>1,576,719,141.97</b>	<b>2,131,771,391.41</b>
<b>Тогтмол зардал</b>		<b>346,325,424.71</b>	<b>309,069,728.00</b>
Гэрэл цахилгааны зардал		30,406,920.31	36,844,721.65
Түлш, халаалтын зардал		304,016,464.40	266,418,986.35

Цэвэр, бохир усны зардал		11,902,040.00	5,806,020.00
<b>Үйл ажиллагааны зардал</b>		<b>1,072,058,678.97</b>	<b>1,429,740,391.41</b>
Хоол		39,984,040.00	38,650,087.00
Эм		371,399,414.78	453,388,363.25
Бусад бараа үйлчилгээний зардал		4,830,000.00	88,544,056.00
Бичиг хэргийн материал		18,591,675.00	26,991,225.00
Тээвэр, шатахууны зардал		60,365,212.80	56,645,622.20
Шуудан холбооны зардал		3,564,549.08	4,370,154.00
Дотоод томилолтын зардал		9,348,000.00	3,490,000.00
Жижиг эд хогшил худалдан авах зардал		60,121,080.00	114,535,841.18
Төлбөр, хураамж, жижиг татварууд		12,730,495.00	29,733,956.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		39,742,340.00	21,300,000.00
Урсгал засварын зардал		35,604,323.68	14,073,950.00
Элэгдлийн зардал		415,777,548.63	578,017,136.78
<b>Хөтөлбөр арга хэмжээний зардал</b>		<b>158,335,038.29</b>	<b>392,961,272.00</b>
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		78,822,000.00	80,826,000.00
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал		55,607,863.00	
Төвлөрүүлэх шилжүүлэг		23,905,175.29	312,135,272.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>3</b>	<b>3,984,163,222.85</b>	<b>5,229,584,614.15</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		<b>3,091,408,769.61</b>	<b>1,806,485,861.42</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>			
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)</b>		-	-
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</b>		<b>278,471,145.40</b>	-
Хөрөнгө худалдсаны гарз		256,729,955.40	
Үнэ төлбөргүй гарсан зардал		21,741,190.00	
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>		<b>(278,471,145.40)</b>	-
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>		<b>2,812,937,624.21</b>	<b>1,806,485,861.42</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр )

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>Татаас, санхүүжилтийн орлого</b>	<b>2,014,800,485.31</b>	<b>3,113,833,960.88</b>
Орон нутгийн төсвөөс	370,230,600.00	621,205,000.00
Нийгмийн даатгалын сангаас	1,644,569,885.31	2,492,628,960.88
<b>Бараа, үйлчилгээний орлого</b>	<b>1,286,459,524.53</b>	<b>1,573,730,330.00</b>
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	820,073,071.53	1,002,470,020.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	466,386,453.00	571,260,310.00
Тусламжийн орлого		
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,301,260,009.84</b>	<b>4,687,564,290.88</b>
<b>Ажиллагчидтай холбогдсон зардал</b>	<b>2,395,203,977.40</b>	<b>3,110,053,326.22</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,141,652,227.51</b>	<b>2,794,869,637.48</b>
Цалин	957,196,656.73	1,067,061,835.54
Цалингийн тусгай нэмэгдлүүд	1,184,455,570.78	1,727,807,801.94
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>253,551,749.89</b>	<b>315,183,688.74</b>
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	219,738,092.40	253,314,109.96
Эрүүл мэндийн даатгалын хураамж	33,813,657.49	61,869,578.78

<b>Бараа ,үйлчилгээний урсгал зардал</b>	<b>1,174,543,090.97</b>	<b>1,555,743,854.20</b>
<b>Тогтмол зардал</b>	<b>346,325,424.71</b>	<b>309,069,728.00</b>
Гэрэл цахилгааны зардал	30,406,920.31	36,844,721.65
Түлш, халаалтын зардал	304,016,464.40	266,418,986.35
Цэвэр, бохир усны зардал	11,902,040.00	5,806,020.00
<b>Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал</b>	<b>669,882,627.97</b>	<b>853,712,854.20</b>
Хоол	39,984,040.00	45,284,137.00
Эм	343,661,825.21	463,027,891.20
Бусад бараа үйлчилгээний зардал	7,500,000.00	103,647,066.00
Бичиг хэргийн материал	20,780,550.00	20,487,550.00
Тээвэр, шатахууны зардал	64,447,605.00	52,563,230.00
Шуудан холбооны зардал	3,564,549.08	4,370,154.00
Дотоод томилолтын зардал	9,348,000.00	3,490,000.00
Жижиг эд хогшил худалдан авах зардал	59,892,200.00	66,691,870.00
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	6,776,000.00	9,235,700.00
Төлбөр, хураамж, жижиг татварууд	14,681,195.00	29,851,456.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	41,242,340.00	21,300,000.00
Урсгал засварын зардал	58,004,323.68	33,763,800.00
<b>Хөтөлбөр арга хэмжээний зардал</b>	<b>158,335,038.29</b>	<b>392,961,272.00</b>
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	78,822,000.00	80,826,000.00
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	55,607,863.00	
Төвлөрүүлэх шилжүүлэг	23,905,175.29	312,135,272.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)</b>	<b>3,569,747,068.37</b>	<b>4,665,797,180.42</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>(268,487,058.53)</b>	<b>21,767,110.46</b>
<b>Хөрөнгийн орлого</b>		
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН(IV)</b>		
Хөрөнгийн бусад зардал	144,438,900.00	61,590,300.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН(V)</b>	<b>144,438,900.00</b>	<b>61,590,300.00</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV) - (V)</b>	<b>(144,438,900.00)</b>	<b>(61,590,300.00)</b>
<b>САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VIII)</b>		
Валютын ханшийн зөрүү		
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX) = (VII) + (VIII)</b>	<b>(412,925,958.53)</b>	<b>(39,823,189.54)</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>548,403,801.82</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>508,580,612.28</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,051,575,735.75	714,371,828.37	7,098,319,992.09	<b>8,864,267,556.21</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга			1,021,775.36	<b>1,021,775.36</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(1,021,775.36)		<b>(1,021,775.36)</b>
Хөрөнгө оруулалтын өсөлт, бууралт				-
Цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн цэвэр орлого				-
Тайлант үеийн үр дүн			1,806,485,861.42	<b>1,806,485,861.42</b>
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	<b>1,051,575,735.75</b>	<b>713,350,053.01</b>	<b>8,905,827,628.87</b>	<b>10,670,753,417.63</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Татаас, санхүүжилтийн орлого</b>	<b>4,222,170,100.00</b>	<b>3,113,833,960.88</b>	<b>(1,108,336,139.12)</b>	<b>73.75</b>
Орон нутгийн төсвөөс	1,020,000,000.00	621,205,000.00	(398,795,000.00)	60.90
Нийгмийн даатгалын сангаас	3,202,170,100.00	2,492,628,960.88	(709,541,139.12)	77.84
<b>Бараа, үйлчилгээний орлого</b>	<b>1,712,540,700.00</b>	<b>1,573,730,330.00</b>	<b>(138,810,370.00)</b>	<b>91.89</b>
Туслах үйл ажиллагаанаас орлогоос санхүүжих	1,712,540,700.00	571,260,310.00	(1,141,280,390.00)	33.36
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого		1,002,470,020.00	1,002,470,020.00	
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>5,934,710,800.00</b>	<b>4,687,564,290.88</b>	<b>(1,247,146,509.12)</b>	<b>78.99</b>
<b>Ажиллагчидтай холбогдсон зардал</b>	<b>4,909,720,900.00</b>	<b>3,110,053,326.22</b>	<b>(1,799,667,573.78)</b>	<b>63.34</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>4,758,326,300.00</b>	<b>2,794,869,637.48</b>	<b>(1,963,456,662.52)</b>	<b>58.74</b>
Цалин	1,318,646,100.00	1,067,061,835.54	(251,584,264.46)	80.92
Цалингийн тусгай нэмэгдлүүд	3,439,680,200.00	1,727,807,801.94	(1,711,872,398.06)	50.23
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>151,394,600.00</b>	<b>315,183,688.74</b>	<b>163,789,088.74</b>	<b>208.19</b>
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	114,394,600.00	253,314,109.96	138,919,509.96	221.44
Эрүүл мэндийн даатгалын хураамж	37,000,000.00	61,869,578.78	24,869,578.78	167.22
<b>Бараа, үйлчилгээний урсгал зардал</b>	<b>1,024,989,900.00</b>	<b>1,617,334,154.20</b>	<b>592,344,254.20</b>	<b>157.79</b>
<b>Тогтмол зардал</b>	-	<b>309,069,728.00</b>	<b>309,069,728.00</b>	
Гэрэл цахилгааны зардал		36,844,721.65	36,844,721.65	
Түлш, халаалтын зардал		266,418,986.35	266,418,986.35	
Цэвэр, бохир усны зардал		5,806,020.00	5,806,020.00	

Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	884,989,900.00	853,712,854.20	(31,277,045.80)	96.47
Хоол	84,000,000.00	45,284,137.00	(38,715,863.00)	53.91
Эм	324,680,000.00	463,027,891.20	138,347,891.20	142.61
Бусад бараа үйлчилгээний зардал	50,000,000.00	103,647,066.00	53,647,066.00	207.29
Бичиг хэргийн материал	12,000,000.00	20,487,550.00	8,487,550.00	170.73
Тээвэр, шатахууны зардал	110,000,000.00	52,563,230.00	(57,436,770.00)	47.78
Шуудан холбооны зардал	6,000,000.00	4,370,154.00	(1,629,846.00)	72.84
Дотоод томилолтын зардал	8,000,000.00	3,490,000.00	(4,510,000.00)	43.63
Жижиг эд хогшил худалдан авах зардал	99,286,000.00	66,691,870.00	(32,594,130.00)	67.17
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	17,489,500.00	9,235,700.00	(8,253,800.00)	52.81
Төлбөр, хураамж, жижиг татварууд	39,000,000.00	29,851,456.00	(9,148,544.00)	76.54
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	25,000,000.00	21,300,000.00	(3,700,000.00)	85.20
Урсгал засварын зардал	109,534,400.00	33,763,800.00	(75,770,600.00)	30.82
<b>Хөтөлбөр арга хэмжээний зардал</b>	<b>140,000,000.00</b>	<b>454,551,572.00</b>	<b>314,551,572.00</b>	<b>324.68</b>
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	140,000,000.00	80,826,000.00	(59,174,000.00)	57.73
Хөрөнгийн бусад зардал		61,590,300.00	61,590,300.00	
Төвлөрүүлэх шилжүүлэг		312,135,272.00	<b>312,135,272.00</b>	
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>5,934,710,800.00</b>	<b>4,727,387,480.42</b>	<b>(1,207,323,319.58)</b>	<b>79.66</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		548,403,801.82	548,403,801.82	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		508,580,612.28	508,580,612.28	

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа<sup>1</sup> илрээгүй.

Аудитаар нийт 174,665.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 87,787.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 86,877.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

Аудитаар илэрсэн 174,665.3 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс 134,818.7 мянган төгрөгөөр давсан, дангаараа эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

#### 3.1 Төлбөрийн акт

**Илрүүлэлт:** Хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг шинжилгээнээс төвлөрүүлсэн орлогоос нэмэлт урамшуулал олгохдоо 78,598.1 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл тооцож суутгаагүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйл: 7.2, 7.2.Энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 6.1.4-т заасан нийгмийн даатгалын төрөлд дараах Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан журмаар даатгуулна: 19 дүгээр зүйлийн 19.1-д “Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна: 19.1.1.Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, 111, 112, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд тус тус заасан цалин хөлс, олговор;” гэж заасантай нийцэхгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

**Шийдвэрлэсэн нь:** Хуультогтоомж зөрчиж суутгаагүй олгосон 78,598.1 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

**Илрүүлэлт:** Төсөв захирагч өөртөө тушаал гарган 9,189.8 мянган төгрөгийн урамшуулал авсан байна. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хууль тогтоомж зөрчиж олгосон 9,189.8 мянган төгрөгийн урамшууллын төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 3.2 Албан шаардлага

**Илрүүлэлт:** Албан хаагчдад илүү цагийн хөлсийг холбогдох журмын дагуу тооцоогүйгээс 32,625.9 мянган төгрөгийг илүү олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 тоот тушаалын хавсралт “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2-т “Илүү цаг, шөнийн цаг, долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтны нэмэгдэл хөлсийг тооцох дундаж цалин хөлсийг тодорхойлохдоо тухайн ажилтны сүүлийн 3 сарын цалин хөлсөөр тооцно” гэсэнтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөх

**Илрүүлэлт:** Тайлант хугацаанд замын хуудсаар жолоочийн тооцоо бодоогүй 3,451.5 төгрөгийн шатахууныг зарцуулсан байна.

Энэ нь УСНББОУС-12 Бараа материал, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 Үнэн зөв байх, 13 дугаар зүйлийн 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.гэснийг болон Зам тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 тоот тушаалаар батлагдсан “Жишиг норм батлах тухай” тушаалыг дагаж мөрдөөгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх

**Илрүүлэлт:** Байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр Бүгд найрамдах Солонгос улсад ажилчдыг шинжилгээний аялалд хамруулахад 50,800.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; гэсэнтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг шинжилгээнээс төвлөрүүлсэн орлогоос нийт дүнгээр 344,019.4 мянган төгрөгийн нэмэлт урамшуулал олгохдоо 78,598.1 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл тооцож суутгаагүй байна.	1	78,598.1	1	78,598.1								
2	Төсвийн захирагч нь өөртөө тушаал гарган 9,189.8 төгрөгийн урамшуулал авсан байна.	1	9,189.8	1	9,189.8								
3	Илүү цагийн хөлсийг холбогдох журмын дагуу тооцоогүйгээс 32,625.9 мянган төгрөгийг илүү олгосон	1	32,625.9			1	32,625.9						
4	3,451.5 төгрөгийн шатахууныг жолооч тус бүрээр тооцоо бодолгүй шууд зардал болгосон	1	3,451.5			1	3,451.5						
5	Солонгос улсад ажилчдыг шинжилгээний аялалд явуулахад 50,800.0 мянган төгрөгийг шилжүүлж бараа үйлчилгээний зардалд бичсэн	1	50,800.0			1	50,800.0						
	<b>Дүн</b>	<b>5</b>	<b>174,665.3</b>	<b>2</b>	<b>87,787.9</b>	<b>3</b>	<b>86,877.4</b>						

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

*/мянган төгрөгөөр/*

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
		Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1	Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 10,185.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ, зарлагын 157,134.8 мянган төгрөгийн 5 гүйлгээг мэдээлээгүй, 8 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	167,319.8	1	167,319.8		
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>167,319.8</b>	<b>1</b>	<b>167,319.8</b>		